

Төвийн эрхэм зорилго:

Зэвсэглэл, техник, материал хэрэгслийн талаарх харьцуулсан судалгаа хийж, вйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг судалж, инновацийг хөгжүүлэх.



Үйл ажиллагааны зорилго:

Гадаад орнуудын зэвсэгт тэмцлийн хэрэгслийн харьцуулалт, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг зохион бүтээх, вйлдвэрлэх, сайжруулах, технологи нутагшуулах талаар судалгаа, туршилт явуулж, инновацийг хөгжүүлэх.

Үйл ажиллагааны гол зорилт:

- Гадаад орнуудын зэвсэглэл, техник, технологид харьцуулсан судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, материал хэрэгслийн чанар байдлыг судалж, сэргээн сайжруулах санал зовломж боловсруулах;
- Зэвсэгт хүчинд инноваци, ондор технологийг нэвтрүүлэх судалгаа явуулах;
- Зэвсэглэл, техник зохион бүтээх, үйлдвэрлэх талаар судалгаа явуулж, батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх санал боловсруулах.

Түүхэн замнал

1995 онд Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэргэд “Эртний монгол цэргийн зэвсэг”-ийн талаар судалгаа хийх орон тооны бус хамтлаг байгуулагдсанаар үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

1997 онд хүрээлэнгийн харъяанд “Туршилт зохион бүтээх тов” байгуулагдаж товийн даргаар хурандаа Г.Гүрбазар томилогдон таван хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн.

2009 оноос “Инновацийн тов”, 2010 оноос “Зэвсэг техник, инноваци судлалын тов”, 2016 оноос “**Байлдааны зэвсэглэл, техник, технологи судлал, инновацийн төв**” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус тов нь эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт зохион бүтээх нийт 41 тосолт ажил гүйцэтгэсэн. Монгол Улсын Засгийн газрын захиалгатай 3 тосол, Батлан хамгаалах яамны захиалгатай 18 тосол, Зэвсэгт хүчний жанжин штабын захиалгатай 8 тосол, сургууль, хүрээлэнгийн дотоодын толовлогоот 12 ажлыг амжилттай гүйцэтгэсэн байна.

Товийн ажилтнууд 22 бүтээлийн загвар, 14 технологи боловсруулж туршилт, үйлдвэрлэл явуулан 50,0 сая тогрогийг орлого оруулсан.

1997, 2006, 2007, 2009, 2011 онуудад сургууль, хүрээлэнгийн тэргүүний товоор шалгарч байсан.

Товийн ажилтнууд дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээ, онол практикийн

хурлуудад 8 илтгэл хэлэлцүүлж 16 огүүлэл, 10 хамтын бүтээл хэвлүүлсэн.

Товийн хоёр бүтээл Монгол Улсын оюуны омчийн газарт зохиогчийн эрхийн хамгаалалт хийсэн.

Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд техник технологийн чиглэлээр 5 бүтээл шалгарч тэргүүн байр эзэлсэн. ЗХЖШ-аас зарласан ШБОС-ын уралдаанд 2 бүтээл тусгай байрын шагнал хүртсэн.